



Nafufill SCC

Бүтээцийн засвар, монтажид зориулсан, өөрөө нягтардаг, суулт өгдөггүй, хурдан хатдаг цутгадаг төрлийн засварын зуурмаг хольц

Бүтээгдэхүүний шинж чанар

- Өөрөө нягтардаг
- Урсамтгай чанар өндөр, үелж тунадаггүй
- Даацын чадварыг сэргээхэд ашиглана
- Химийн түрэмгий орчин, түүний дотор далайн ус болон мөс хайлуулах бодист тэсвэртэй чанар маш өндөр
- Ашиглалтын техникийн үзүүлэлтүүдээ богино хугацаанд бүрдүүлдэг
- Галд тэсвэртэй
- Хэрэглэхэд хялбар бөгөөд тохиромжтой

Хэрэглээний хүрээ

- Иргэний (үйлдвэр, орон сууц, олон нийтийн гэх мэт) болон инженерчлэлийн (дэд бүтэц, усны барилга байгууламж, тээвэр, эрчим хүчний гэх мэт) барилга байгууламжийн бетон болон төмөр бетон бүтээцийн засварын зуурмаг хольц
- Өтгөн арматурчлалтай, нарийн төвөгтэй хэлбэртэй болон урьдчилан хүчитгэсэн бүтээцэд нягтруулагч ашиглахгүйгээр цутгахад нэн тохиромжтой
- Хэв хашмал задлах хугацааг хэмнэж, ашиглалтын бүрэн ачааллыг маш богино хугацаанд авахад нэн тохиромжтой
- Ажлын талбайн нөхцөлд өндөр чанартай тусгай бетон зуурч бэлтгэх боломжгүй үед бэлэн шийдэл болно
- Усан доорх цутгалт болон усны түвшний өөрчлөлтийн бүсэд ашиглахад нэн тохиромжтой
- Тоног төхөөрөмж, бүтээцийн чигжээс, монтажид (түүний дотор анкер бэхэлгээ) хэрэглэнэ
- Барилгын суурь болон хөрс, чулуулгийг бэхжүүлэхэд хэрэглэнэ
- Техникийн шаардлагуудыг хангасан:
 - ГОСТ 31384-2008 «Бетон болон төмөр бетон бүтээцийг зэврэлтээс хамгаалах» стандарт болон СП 28.13330-2012 «Барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах» дүрмийн дагуу бетон болон төмөр бетон бүтээцийг зэврэлтээс хамгаалахад тавигдах шаардлага;
 - ГОСТ 56378-2015 «Бетон бүтээцийг хамгаалах, засварлах материал, систем. Бүтээцийг сэргээх үеийн засварын хольц болон контактны бүсийн барьцалдах нэгдэлд тавигдах шаардлага. EN 1504-3:2005», стандартын R4 ангилал.

Хэрэглэх заавар

Гадаргууг бэлтгэх ажил

Бетон гадаргуу нь тоос шороо, тос тослогоо, цементийн сүү (наалдамхай үе) болон бусад барьцалдалтыг муутгах бодисоос бүрэн цэвэрлэгдсэн байх ёстой. Бетонд тавигдах тусгайлсан шаардлага байхгүй тохиолдолд шахалтын бат бэх нь 25 МПа-аас багагүй, хуулалтын (барьцалдах) бат бэх нь 1,5 МПа-аас багагүй байх ёстой. Суурь гадаргууг урьдчилан чийгшүүлэх шаардлагатай бөгөөд гадаргуу нь иржгэр-чийглэг байх ёстой.

Зуурмаг бэлтгэх

Nafufill SCC-ийг урьдчилан хэмжсэн усанд тасралтгүй хутгах явцдаа бага багаар хийж, бөөгнөрөлгүй, нэгэн төрлийн бетон зуурмаг болтол нь хутгана. Зуурмагийг бэлтгэхдээ албадан ажиллагаатай зуурагч (миксер) эсвэл бага эргэлттэй, хоёр далавчит хутгуурыг ашиглана. Нэг уут (25 кг) хуурай хольцод 2,5–2,75 литр ус шаардлагатай. Хутгах хугацаа 3 минутаас багагүй байна. Их хэмжээгээр цутгалт хийх тохиолдолд зориулалтын холих болон тээвэрлэх (шахах) төхөөрөмжийг ашиглана. Төхөөрөмжийг «Ашиглалтын заавар»-ын дагуу ажилд бэлтгэх шаардлагатай. Материалтай ажиллахдаа барилгын материалыг шахаж тээвэрлэх дүрмийг баримтлах шаардлагатай (хүрээлэн буй орчны нөхцөл байдлаас шалтгаалан зуурмагийн өтгөн шингэнийг зөв сонгох, шахах хоолойг урьдчилан тослох/чийгшүүлэх гэх мэт).

Нэмэлт барьцалдуулагч бодис болон нэмэлтүүдийг ашиглахыг хориглоно.

Цутгалт хийх

Бетон зуурмагийг бэлтгэсэн даруйд цутган байрлуулна. Дефекттэй хэсэгт цутгалт хийх хугацаа 15 минутаас хэтэрсэн тохиолдолд үл ялиг нягтруулалт (чигжих, доргиулах гэх мэт) хийх шаардлагатай. Цутгалт хийх явцад болон цутгасны дараах эхний цагуудад ажлын талбайн ойр орчимд хүчтэй чичиргээ, доргилт үүсгэхээс зайлсхийх хэрэгтэй.

Зуурмагийг арчлах заавар

Зуурмаг барьцалдах, хатуурах үйл явц нь цутгалтын зузаанаас шалтгаалж бага эсвэл их хэмжээний дулаан ялгаруулалттай явагддаг.

Nafufill SCC-ийг нарны шууд тусгал болон салхины нөлөөгөөр хэт хурдан хатахаас хамгаалах шаардлагатай.

Арчилгааны үргэлжлэх хугацаа нь гадаад орчны нөхцөл байдлаас шалтгаалах бөгөөд ердийн нөхцөлд 1–3 хоног байна.



Nafufill SCC-ийн техникийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд*	Хэмжих нэгж	Утга*	Тайлбар
Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ	Мм	5	
Зуурмагийн нягт	кг/м ³	2300	-
Бетон зуурмагийн урсамтгай чанарын марк:			
- дайргагүй	-	P1	конусын тархалт 27–31 см
- 5-20 мм-ийн хэмжээтэй дайрга	-	P1	
- 20-40 мм-ийн хэмжээтэй дайрга	-	P5	конусын суулт > 20 см
Суналт/шахалтын бат бэх, багагүй	МПа	6/30	1 хоногийн дараа
	МПа	7,5/45	7 хоногийн дараа
	МПа	10/60	28 хоногийн дараа
Динамик уян хатан чанарын модуль E	МПа	≥25 000	28 хоногийн дараа
Ус нэвтрүүлдэггүй чанар	МПа	≥1,2	≥ W12, 28 хоногийн дараа
Хүйтэнд тэсвэртэй	Цикл	≥500	≥ F500, 28 хоногийн дараа
Суулт	мм/м	≤ 0	28 хоногийн дараа
Зарцуулалт (хуурай хольц)**	кг/м ² /мм	2	
Зуурмагийн ажиллах хугацаа	минут	40	
Өөрөө нягтрах чанар	минут	15	хутгахгүй байх үед
Давхаргын зузаан	мм	15	давхаргын хамгийн бага зузаан
	мм	300	дайргагүй үеийн давхаргын хамгийн их зузаан
	мм	700	дайргатай үеийн давхаргын хамгийн их зузаан
	мм	1500	дайрга нэмж хэсэгчилсэн эвдрэлийг засварлах
Ашиглах нөхцөл	° C	≥5 - ≤ 30	температур агаар / суурь / материалын
Зуурах найрлагын харьцаа			
- дайргагүй,	жингийн хэсэг	100 : 10 - 11	Nafufill SCC : ус
- 5-20 мм-ийн хэмжээтэй дайрга	жингийн хэсэг	100 : 11,1 : 47,9	Nafufill SCC : ус : дайрга
- 20-40 мм-ийн хэмжээтэй дайрга	жингийн хэсэг	100 : 11,4 : 47,9	Nafufill SCC : ус : дайрга

* — үндсэн үзүүлэлтүүдийг дайргагүйгээр тооцсон болно.

Nafufill SCC-ийн нэмэлт мэдээлэл

Өнгө	Цементэн саарал
Нийлүүлэлт	25 кг-ын ууттай
Хадгалалт	Үйлдвэрийн битүүмжилсэн баглаа боодолтой нөхцөлд хадгалах хугацаа 12 сараас багагүй байна. Сэрүүн, хуурай байранд хадгална.
Устгалд оруулах	Сав баглаа боодлыг бүрэн хоослох шаардлагатай. Хог хаягдлыг орон нутгийн дүрэм журмын дагуу устгана.

Сав баглаа боодол дээрх, аюулгүй байдлын мэдээллийн хуудсанд заасан хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын шаардлагыг дагаж мөрдөх шаардлагатай.

* — техникийн бүх үзүүлэлтүүдийг агаарын +23хэм болон 50%-ийн харьцангуй чийглэгт тодорхойлсон болно

** — зарцуулалтын үзүүлэлт нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг тул нарийн тодорхойлохын тулд ажлын талбай дээр туршилтын цутгалт хийж үзэхийг зөвлөж байна.

Энэхүү техникийн тодорхойлолтод тусгагдсан мэдээллүүд нь бидний туршлага дээр үндэслэгдсэн бөгөөд баримт бичгийн тухайн хувилбар хүчин төгөлдөр байх хугацаанд үнэн зөв болно. Техникийн тодорхойлолтод заасан өгөгдлүүдийг ямар ч тохиолдолд тухайн барилгын бүтээцийн онцлог, гүйцэтгэх ажлын зорилго, ялангуяа ажлын талбайн орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн зохицуулж хэрэглэх шаардлагатай. Бүх өгөгдөл нь ажил гүйцэтгэхэд заавал мөрдөх ёстой барилгын хүчин төгөлдөр норм, дүрэм, журамтай шууд уялдсан болно. Бид өөрсдийн өгөгдлийн үнэн зөв байдлын хариуцлагыг зөвхөн материал нийлүүлэх гэрээ болон тус гэрээнд заасан нөхцөлийн хүрээнд хүлээнэ. Нийлүүлэлтийн гэрээнд нийлүүлэлтийн нөхцөл болон харилцагчийн үйлчилгээний доод түвшнийг тусгасан болно. Манай ажилтнуудын зүгээс өгсөн, техникийн тодорхойлолтод зааснаас зөрүүтэй аливаа зөвлөмжүүд нь зөвхөн бичгээр үйлдэгдэж, гарын үсэг зурагдсан (баталгаажсан) тохиолдолд л хүчин төгөлдөрт тооцогдно. Барилгын хүчин төгөлдөр норм, дүрмийг ямар ч тохиолдолд заавал дагаж мөрдөх ёстой.

Хэвлэгдсэн: 04/17. Техникийн тодорхойлолтын энэхүү хувилбарт өөрчлөлтүүд орсон болно. Өмнөх хэвлэлүүд хүчингүйд тооцогдох тул цаашид ашиглахыг хориглоно. Шинэчилж засварласан хувилбар нийтлэгдэхэд энэхүү хэвлэл нь хүчингүйд тооцогдно.

«Эм-Си Баухеми» ХХК • Авиаконструкторуудын өргөн чөлөө, 35-р байрны 4 тоот • 197373, Санкт-Петербург хот •
Утас: 8-800-555-06-05 (ОХУ-ын нутаг дэвсгэрээс суурин болон гар утаснаас хийх бүх дуудлага үнэ төлбөргүй)

e-mail: info@mc-bauchemie.ru, www.mc-bauchemie.ru